



УВС АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН ГАЗАР

# УВС АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 2015 он



УЛААНГОМ ХОТ 2016 ОН

## ХҮН АМ, ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### А. Судалгааны зорилго

Увс аймгийн хүн амын тоо, түүний өсөлт, нас хүйсний бүтцэд болон хүн ам зүйн үндсэн үзүүлэлтэд гарсан өөрчлөлтүүд, цаашдын чиг хандлага, хүн амын нийгмийн үзүүлэлтүүдийн чиг хандлагыг харуулсан мэдээлэл, санал дүгнэлтээр аймгийн удирдлагын болон бусад хэрэглэгчдийн хэрэгцээг хангах зорилготой болно.

### Б. Судалгааны агуулга

Аймгийн хэмжээний хүн амын тооны өсөлт, нас, хүйсийн бүтэц, түүний өөрчлөлт, хүйсийн харьцаа, хүн ам зүйн ачаалал, тархан суурьшилт болон хүн амын ердийн хөдөлгөөн, өрх хүн амын нийгмийн зарим үзүүлэлтүүдийн судалгааг жилийн эцсийн мэдээ тайланг үндэслэн хийлээ.

Судалгаанд 2010-2015 оны хооронд 6 жилийг хамруулж, 6 бүлгийн үзүүлэлтээр оны зэрэгцүүлэлт хийсний дээр зарим үзүүлэлтийг график дүрслэлээр үзүүлээ.

### В. Судалгааны арга зүй

Статистикийн албан ёсны судалгаанд тулгуурлан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, өмнөх онуудтай харьцуулан дүгнэх аргаар судалгааг хийлээ.

Хүн ам, нийгмийн зарим үзүүлэлтүүдийн тодорхойлолт, тооцох аргачлалыг хавсаргалаа.

*Нэр томъёоны тайлбар:*

- 1. Суурин хүн ам** - Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ.
- 2. Өрх** – Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдарлын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ.
- 3. Нэг өрхөд ногдох хүний тоо** – Нэг өрхөд ногдох хүний тоог тодорхойлохдоо өрхөд тоологдсон хүний тоог өрхийн тоонд харьцуулна.
- 4. Хүйсийн харьцаа** – Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.
- 5. Хүн ам зүйн ачаалал** - Хүн ам зүйн ачаалал гэсэн үзүүлэлт нь 0-14 насны болон 65, түүнээс дээш настай хүн амын тоог 15-64 насны хүн амын тоонд харьцуулсан харьцааг илэрхийлдэг.

6. **Хүн амын нас-хүйсийн суварга** - Нас- хүйсний суварга нь хүн амыг хүйсний ялгавраар нь мөн нас, насны бүлэг бүрийн хүний тоо, харьцаагаар маш ойлгоомжтой дүрслэн харуулда.
7. **Төрөлтийн ерөнхий коэффициент** - Энэ үзүүлэлт нь тухайн жилд 1000 хүн амд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж тооцдог.
8. **Төрөлтийн тусгай коэффициент** - Төрөх насны буюу (15-49 ) 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.
9. **Төрөлтийн нийлбэр коэффициент** - Төрөх насны нэг эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн дундаж бөгөөд 1 эмэгтэйн эсвэл 1000 эмэгтэйн нийт амьдарлынхаа туршид төрүүлэх дундаж тоог илэрхийлнэ.
10. **Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент** - Тухайн насны бүлгийн эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоог мөн насны бүлгийн эмэгтэйчүүдэд харьцуулсан харьцааг хэлнэ.
11. **Нас баралтын ерөнхий коэффициент** - Нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулцуулсан харьцаа бөгөөд энэ үзүүлэлт нь 1000 хүн амд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.
12. **Нялхасын нас баралтын коэффициент** - Нэг хүртэл насандаа нас барсан хүүхдийн тоог тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулцуулсан харьцаагаар илэрхийлдэг үзүүлэлт юм.
13. **Өнчин болон хагас өнчин хүүхэд** - Өнчин хүүхдийн тоог тодорхойлохдоо бүтэн өнчинд эцэг, эх нь 2-лаа нас барсан хүүхдийг, хагас өнчинд эцэг, эх 2-ын аль нэг нь нас барсан хүүхдийг оруулж бүртгэнэ.
14. **Өрх толгойлсон хүний тоо** - Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоонд хүүхэдтэй эсэхийг үл харгалзан эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоог авч бүртгэнэ. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөд гэр бүлгүй, өрхөө толгойлон амьдарч байгаа эрэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.
15. **Тахир дутуу хүний тоо** – Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг, өөрчлөлт, өвчин тарилгын дараах хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун санааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон МонголУлсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ гэж тодорхойлсон бөгөөд хөдөлмөр магадлах коммиссоор тахир дутуу болох нь тогтоогдсон хүнийг авч бүртгэнэ.

## 1. ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ


Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бүртгэлд суурилсан хүн ам, өрхийн мэдээллийн сангаас үндэслэн гаргасан хүн амын тоогоор 2015 оны жилийн эцэст 40.4 мянган эрэгтэй, 39.9 мянган эмэгтэй нийт 80.4 мянган хүн тоологдсон байна. Нийт хүн амын 49.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харицаа 101.1 хувьтай байгаа нь 100 эмэгтэйд 101 эрэгтэй ногдож байна. Хүн ам 2010 оноос 5.6 мянган хүнээр буюу 7.5 хувиар, 2014 оноос 4.6 мянган хүнээр буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 1. Хүн амын тоо, оноор

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015
Суурин хүн ам, хүйсээр						
Бүгд	74784	74448	74026	75518	75737	80396
Үүнээс:						
эрэгтэй	37400	37079	36977	37598	37976	40428
эмэгтэй	37384	37369	37049	37920	37761	39968
Хот хөдөөгийн хүн ам						
Бүгд	74784	74448	74026	75518	75737	80396
Үүнээс:						
хот, тосгон	23011	22849	25098	25574	26176	27658
хөдөөгийн	51773	51599	48928	49944	49561	52738
Жилийн дундаж суурин хүн ам						
Бүгд	76096	74617	74237	74773	75628	78067
Үүнээс:						
эрэгтэй	38106	37240	37028	37288	37787	39202
эмэгтэй	37990	37377	37209	37485	37841	38865

График.1 Хүн ам, жилийн дундаж өсөлт

### Хүн амын жилийн дундаж өсөлт, онуудаар




## Хүснэгт 2. Хүн амын тоо, хүйсээр сумаар

Сум	2010		2011		2012		2013		2014		2015	
	Хүн ам	Үүнээс эмэгтэй	Хүн ам	Үүнээс эмэгтэй	Хүн ам	Үүнээс эмэгтэй	Хүн ам	Үүнээс эмэгтэй	Хүн ам	Үүнээс эмэгтэй	Хүн ам	Үүнээс эмэгтэй
Баруунтуруун	2744	1206	2716	1191	2474	1184	2385	1168	2449	1187	2648	1282
Бөхмөрөн	2149	1061	2188	1078	2102	1044	2180	1072	2093	1030	2165	1056
Давст	1734	852	1770	877	1773	877	1748	878	1570	772	1572	768
Завхан	1753	899	1677	860	1698	882	1722	893	1734	891	1803	927
Зүүнговь	2568	1267	2498	1242	2616	1295	2413	1172	2640	1287	2705	1318
Зүүнхангай	2300	1123	2297	1104	2226	1095	2231	1094	2104	1011	2240	1074
Малчин	2351	1127	2311	1133	2434	1191	2404	1176	2351	1133	2486	1197
Наранбулаг	4459	2208	4433	2185	4413	2210	4356	2185	4026	2013	4043	2020
Өлгий	2085	1038	2088	1037	2114	1055	2121	1062	2147	1063	2347	1177
Өмнөговь	4177	2119	4170	2110	4320	2173	4348	2204	4192	2097	4450	2227
Өндөрхангай	3255	1617	3144	1553	3153	1577	3155	1582	3031	1500	3177	1583
Сагил	2294	1126	2239	1095	2178	1069	2267	1103	2201	1080	2343	1153
Тариалан	3783	1909	3773	1906	3736	1892	3679	1860	3714	1857	3853	1917
Түргэн	2021	1014	2026	1016	2018	1012	2015	1015	2018	1006	2129	1051
Тэс	5207	2570	5263	2602	5126	2520	5280	2607	5056	2424	5218	2562
Ховд	2132	1085	2194	1118	2200	1134	2222	1144	2237	1133	2391	1207
Хяргас	2581	1243	2545	1233	2397	1171	2426	1178	2314	1131	2474	1201
Цагаанхайрхан	1978	965	2101	1025	1950	969	1972	978	2011	995	2003	987
Улаангом	25213	12955	25015	13004	25098	12699	26594	13549	27849	14151	30349	15261
Дүн	74784	37384	74448	37369	74026	37049	75518	37920	75737	37761	80396	39968

Нийт хүн амын 37.7 хувь нь Улаангом суманд, 62.3 хувь нь бусад суманд амьдарч байна.

График 2. 2015 оны нийт хүн ам, сумаар, бүтцээр

## 2015 оны суурин хүн ам /сумаар, бүтцээр/




Хүн амын 34.4 хувь буюу 27.6 мянга нь аймгийн төв, суурин газарт, 20.8 хувь буюу 16.7 мянга нь сумын төвд, 44.8 хувь буюу 36.0 мянга нь хөдөөд амьдарч байна.

### Хүснэгт 3. Хүн амын тоо,байршлаар, сумаар

Сумын нэр	Бүх хүн ам			ҮҮНЭЭС								
				Аймгийн төвд			Сумын төвд			Хөдөөд		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Баруунтуруун	2648	1366	1282	0	0	0	1758	898	860	890	468	422
Бөхмөрөн	2165	1109	1056	0	0	0	753	379	374	1412	730	682
Давст	1572	804	768	0	0	0	638	311	327	934	493	441
Завхан	1803	876	927	0	0	0	811	401	410	992	475	517
Зүүнговь	2705	1387	1318	0	0	0	939	460	479	1766	927	839
Зүүнхангай	2240	1166	1074	0	0	0	759	382	377	1481	784	697
Малчин	2486	1289	1197	0	0	0	656	342	314	1830	947	883
Наранбулаг	4043	2023	2020	0	0	0	1118	565	553	2925	1458	1467
Өлгий	2347	1170	1177	0	0	0	506	244	262	1841	926	915
Өмнөговь	4450	2223	2227	0	0	0	1326	647	679	3124	1576	1548
Өндөрхангай	3177	1594	1583	0	0	0	1003	508	495	2174	1086	1088
Сагил	2343	1190	1153	0	0	0	730	352	378	1613	838	775
Тариалан	3853	1936	1917	0	0	0	1521	746	775	2332	1190	1142
Түргэн	2129	1078	1051	0	0	0	676	345	331	1453	733	720
Тэс	5218	2656	2562	0	0	0	897	444	453	4321	2212	2109
Ховд	2391	1184	1207	0	0	0	865	415	450	1526	769	757
Хяргас	2474	1273	1201	0	0	0	836	428	408	1638	845	793
Цагаанхайрхан	2003	1016	987	0	0	0	937	454	483	1066	562	504
Улаангом	30349	15088	15261	27658	13725	13933	0	0	0	2691	1363	1328
2015* он	80396	40428	39968	27658	13725	13933	16729	8321	8408	36009	18382	17627
2014 он	75737	37976	37761	26176	12882	13294	14336	7114	7222	35225	17980	17245

График 3. 2015 оны хүн амын жилийн дундаж өсөлт, сумаар

### Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь, сумдаар



Графикаас харахад сүүлийн нэг жилийн хугацаанд Увс аймгийн хэмжээнд Өлгий сум хамгийн их өсөлт 9.3 хувь буюу 200 хүнээр нэмэгдсэн бол бууралтын хувь хамгийн их Цагаанхайрхан сум -0.4 хувь буюу 8 хүнээр буурсан байна. Аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь нь 6.2 байгаа нь 4.6 мянган хүнээр өссөнийг харуулж байна.

Өлгий, Баруунтуруун, Ховд, Улаангом, Хяргас, Сагил, Зүүнхангай сумдын хүн ам тоо 0.3-3.1 пунктээр аймгийн дунджаас өсч, бусад сумдын хүн амын тоо 0.5-6.1 пунктээр аймгийн дунджаас доогуур байна.

## 2. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ

Аймгийн нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2010 онд 50.0 хувь, 2013 онд 50.2 хувь, 2015 онд 49.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4. Нийт хүн ам, мянган хүнээр, хүйсээр





Манай аймгийн нэг өрхөд 3.8 хүн ногдож байна. Энэ үзүүлэлт нь 2012 оноос 0.08 пунктээр, 2013 оноос 0.07 пунктээр тус тус буурч, харин 2014 оноос 0.14 пунктээр нэмэгдсэн байна.

Хүйсийн харьцаа 2010 онд 100.5, 2015 онд 101.1 байгаа нь манай аймгийн хүн амд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа бөгөөд хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна. Энэ онд хүйсийн харьцаа 101.1 байгаа нь 100 эмэгтэйд 101 эрэгтэй ногдож байна.

Хүснэгт 4. Өрх, хүн амын тоо

Он	Өрх	Хүн амын тоо	Жилийн дундаж өсөлт	Нэг өрхөд ногдох хүний тоо	Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал
2010	19732	74784	-3.4	3.79	100.5	72.8
2011	19799	74448	-0.4	3.76	99.2	71.5
2012	19844	74026	-0.6	3.73	100.0	69.6
2013	20248	75518	2.0	3.72	99.2	69.7
2014	20719	75737	0.3	3.65	100.6	59.4
2015	21212	80396	6.2	3.79	101.1	57.6

Зураг 5. 2010, 2015 онуудын нас хүйсийн суврага



Манай аймгийн энэ оны нас хүйсийн суврагыг залуу идэр насанд эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээсээ өндөр байгаа бөгөөд 35-60 нас хүртэл эмэгтэйчүүдийн тоо, эрэгтэйчүүдийн тоо ижил түвшинд, 60 наснаас дээш эмэгтэйчүүдийн тоо 2 дахин өсөх хандлагатай байна.

Хүн ам зүйн бодлогын гол асуудлуудын нэг нь хүн ам зүйн ачаалал юм. Хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны мянган хүнд ногдох тэжээлгэгч /өндөр настан,

хүүхэд/ хүний тоо 2010 онд 728, 2012 онд 696, 2014 онд 594, 2015 онд 576 байна. Увс аймгийн хүн ам зүйн ачаалал буурах хандлагатай харагдаж байна. Хүн ам зүйн ачаалал өндөр байх нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амын аж байдлыг дээшлүүлэхэд сөрөг нөлөөтэй байдаг.

## Хүснэгт 5. Хүн амын тоо, хүйсээр, насны бүлгээр

Насны бүлэг	2010		2011		2012		2013		2014		2015	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Нийт хүн ам	74784	37384	74448	37369	74026	37049	75518	37920	75737	37761	80396	39968
16 хүртэл насны	27493	13540	27139	13292	26476	13000	27028	13275	27284	13331	28334	13856
16-19	6296	3088	6099	3082	6271	3089	6175	3050	5400	2681	6574	3176
20-24	5952	2801	6027	2882	6092	2931	6200	3043	6193	2919	7870	3744
25-29	5954	2928	5942	2945	5782	2823	6006	2983	6203	3014	6533	3112
30-34	5507	2765	5436	2736	5456	2750	5443	2700	5519	2680	5601	2745
35-39	5306	2665	5333	2686	5245	2622	5278	2651	5234	2614	5237	2595
40-44	5260	2671	5155	2645	5141	2612	5113	2555	5056	2566	5006	2536
45-49	4176	2094	4325	2231	4304	2207	4547	2367	4622	2403	4751	2468
50-54	3055	1542	3154	1570	3350	1669	3504	1778	3787	1915	3779	1925
55-59	1762	909	1933	991	1998	1041	2226	1156	2433	1258	2635	1395
60 ба дээш насны	4023	2381	3905	2309	3911	2305	3998	2362	4006	2380	4076	2416

## Хүснэгт 6. Хүн амын тоо, насны ангилалаар, сумаар


Сум	Хүн амын тоо бүгд		0-14 насны хүүхэд		16 хүртэл насны хүн амын тоо		18 хүртэл насны хүн амын тоо		16 дээш насны хүн амын тоо		18 дээш насны хүн амын тоо		16-34 насны залуучуудын тоо		15-60 хөдөлмөрийн насны хүн амын тоо		60 дээш өндөр настан	
	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015
Баруунтуруун	2449	2648	755	778	807	834	895	938	1642	1814	1554	1710	741	928	1540	1725	154	145
Бөхмөрөн	2093	2165	717	703	766	759	863	857	1327	1406	1230	1308	642	715	1279	1359	97	103
Давст	1570	1572	554	520	588	552	655	617	982	1020	915	955	450	519	943	985	73	67
Завхан	1734	1803	593	598	641	626	722	717	1093	1177	1012	1086	499	567	1042	1111	99	94
Зүүнговь	2640	2705	913	943	964	1003	1084	1121	1676	1702	1556	1584	853	871	1589	1629	138	133
Зүүнхангай	2104	2240	696	695	740	733	830	835	1364	1507	1274	1405	610	752	1283	1420	125	125
Малчин	2351	2486	825	847	888	898	1006	1023	1463	1588	1345	1463	662	792	1373	1488	153	151
Наранбулаг	4026	4043	1516	1471	1604	1574	1773	1744	2422	2469	2253	2299	1233	1319	2307	2379	203	193
Өлгий	2147	2347	785	797	848	858	948	979	1299	1489	1199	1368	627	796	1265	1454	97	96
Өмнөговь	4192	4450	1552	1585	1649	1686	1835	1898	2543	2764	2357	2552	1282	1480	2448	2669	192	196
Өндөрхангай	3031	3177	952	986	1023	1049	1157	1191	2008	2128	1874	1986	1004	1092	1926	2027	153	164
Сагил	2201	2343	833	860	878	907	965	1007	1323	1436	1236	1336	594	692	1271	1394	97	89
Тариалан	3714	3853	1535	1490	1632	1575	1788	1777	2082	2278	1926	2076	1069	1292	2020	2207	159	156
Түргэн	2018	2129	661	715	696	754	780	838	1322	1375	1238	1291	664	682	1261	1317	96	97
Тэс	5056	5218	1818	1815	1951	1925	2165	2170	3105	3293	2891	3048	1518	1713	2967	3130	271	273
Ховд	2237	2391	788	808	847	868	952	985	1390	1523	1285	1406	617	742	1321	1456	128	127
Хяргас	2314	2474	818	828	884	878	994	1014	1430	1596	1320	1460	653	795	1379	1518	117	128
Цагаанхайрхан	2011	2003	653	655	702	696	780	784	1309	1307	1231	1219	655	661	1264	1247	94	101
Улаангом	27849	30349	8633	9633	9176	10159	10229	11293	18673	20190	17620	19056	8942	10170	17656	19078	1560	1638
Дүн	75737	80396	25597	26727	27284	28334	30421	31788	48453	52062	45316	48608	23315	26578	46134	49593	4006	4076

## Хүснэгт 7. Эмэгтэй хүн амын тоо, насны ангилалаар, сумаар

Сум	Хүн амын тоо бүгд		0-14 насны хүүхэд		16 хүртэл насны хүн амын тоо		18 хүртэл насны хүн амын тоо		16 дээш насны хүн амын тоо		18 дээш насны хүн амын тоо		16-34 насны залуучуудын тоо		15-60 хөдөлмөрийн насны хүн амын тоо		60 дээш өндөр настан	
	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015	2014	2015
Баруунтуруун	1187	1282	365	389	389	412	430	453	798	870	757	829	328	409	733	806	89	87
Бөхмөрөн	1030	1056	336	333	361	357	419	412	669	699	611	644	319	341	638	662	56	61
Давст	772	768	266	242	286	260	319	299	486	508	453	469	209	251	466	490	40	36
Завхан	891	927	316	319	342	335	383	385	549	592	508	542	242	275	519	554	56	54
Зүүнговь	1287	1318	424	452	449	481	500	533	838	837	787	785	402	399	774	778	89	88
Зүүнхангай	1011	1074	326	322	342	340	386	385	669	734	625	689	279	348	608	677	77	75
Малчин	1133	1197	404	413	427	439	479	485	706	758	654	712	290	345	640	696	89	88
Наранбулаг	2013	2020	784	767	826	815	908	900	1187	1205	1105	1120	573	615	1105	1134	124	119
Өлгий	1063	1177	371	393	404	421	453	481	659	756	610	696	304	391	632	723	60	61
Өмнөговь	2097	2227	751	773	801	825	899	934	1296	1402	1198	1293	635	731	1224	1327	122	127
Өндөрхангай	1500	1583	451	467	488	495	560	565	1012	1088	940	1018	488	545	962	1025	87	91
Сагил	1080	1153	396	412	416	434	463	487	664	719	617	666	293	345	622	684	62	57
Тариалан	1857	1917	773	747	820	783	890	877	1037	1134	967	1040	509	624	993	1085	91	85
Түргэн	1006	1051	335	358	354	375	401	424	652	676	605	627	317	331	607	633	64	60
Тэс	2424	2562	852	874	929	924	1027	1053	1495	1638	1397	1509	676	812	1417	1530	155	158
Ховд	1133	1207	391	395	424	425	480	492	709	782	653	715	310	373	663	734	79	78
Хяргас	1131	1201	400	407	435	432	490	501	696	769	641	700	303	364	668	729	63	65
Цагаанхайрхан	995	987	317	322	337	341	377	382	658	646	618	605	313	304	621	606	57	59
Улаангом	14151	15261	4244	4697	4501	4962	5042	5523	9650	10299	9109	9738	4504	4974	8987	9597	920	967
Дүн	37761	39968	12502	13082	13331	13856	14906	15571	24430	26112	22855	24397	11294	12777	22879	24470	2380	2416

2015 онд нийт хүн амын 35.2 хувь нь 0-15 насны хүүхэд, 59.7 хувь нь 16-59 насны, 5.1 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүн ам байна. Хүн амын 68.3 хувь нь хүүхэд залуучууд буюу 0-34 насны 54.9 мянган хүн байна.

График 6. Суурин хүн ам, насны бүлгээр, мянган хүнээр



Нийт хүн амыг 2015 оныг 2010 онд харьцуулж үзэхэд 0-15 насны хүүхэд 4.7 мянган хүнээр буюу 10.9 хувиар, хөдөлмөрийн насны хүн 0.8 мянган хүнээр буюу 2.9 хувиар, тэтгэврийн насны хүн 0.1 мянган хүнээр буюу 2.5 хувиар тус тус өссөн байна.

### 3. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ


Улсын хэмжээнд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2014 оны байдлаар 69.6, эрэгтэйчүүдийнх 65.9, эмэгтэйчүүдийнх 75.5 байна. Монгол улсын хэмжээнд манай аймгийн хүн амын дундаж наслалт 68.3 байгаа нь 21 аймгийн сүүлээсээ хоёрдугаарт Хөвсгөл аймгийн өмнө орж байна.

Хүснэгт 11. Хүн амын дундаж наслалт

	2010	2011	2012	2013	2014
Улсын дундаж наслалт	68.1	68.3	68.7	69.1	69.6
Аймгийн дундаж наслалт	65.5	66.6	67.3	67.7	68.3

Улсын дундаж наслалт 2010 онд 68.1 аймгийн дундаж наслалт 65.5 байсан бол 2014 онд улсын дундаж наслалт 69.6, аймгийн дундаж наслалт 68.3 болж жил дараалан нэмэгдэж байна. Улсын дундаж наслалт 2010 оныхоос 1.5 жил, 2013 оноос 0.5 жил, мөн аймгийн дундаж наслалт 2010 оныхоос 2.8 жил, 2013 оныхоос 0.6 жилээр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 7. Хүн амын дундаж наслалт



Манай аймгийн хүн амын дундаж наслалт улсын дундаж наслалтаас 2010 онд 2.6 жилээр, 2012 онд 1.4 жилээр, 2014 онд 1.3 жилээр тус тус доогуур байна.


## Хүснэгт 8. Хүн амын дундаж наслалт, бүс аймаг, нийслэлээр

Аймаг нийслэл	2010	2011	2012	2013	2014
Бүгд	68.1	68.3	68.7	69.1	69.6
Баруун бүс					
Баян-Өлгий	69.8	71.0	71.7	72.2	72.6
Говь-Алтай	66.0	67.1	67.9	68.2	68.8
Завхан	66.4	67.5	68.2	68.6	69.2
Увс	65.5	66.6	67.3	67.7	68.3
Ховд	68.8	69.9	70.7	71.1	71.7
Хангай бүс					
Архангай	67.7	68.8	69.5	69.9	70.5
Баянхонгор	66.1	67.2	67.9	68.3	68.9
Булган	69.3	70.5	71.3	71.7	72.3
Орхон	67.9	69.1	69.8	70.3	70.8
Өвөрхангай	67.9	67.6	68.3	68.8	69.3
Хөвсгөл	63.6	63.4	64.1	65.3	65.8
Төвийн бүс					
Говьсүмбэр	69.9	71.1	71.8	72.3	72.9
Дархан-Уул	65.7	66.8	67.5	67.9	68.5
Дорноговь	67.3	68.4	69.2	69.6	70.2
Дундговь	70.2	71.4	72.2	72.6	73.2
Өмнөговь	68.5	69.7	70.4	70.8	71.4
Сэлэнгэ	68.9	70.1	70.8	71.3	71.9
Төв	69.8	70.3	71	71.5	72.1
Зүүн бүс					
Дорнод	64.0	65.1	65.7	67.8	68.4
Сүхбаатар	68.9	70.0	70.8	71.2	71.8
Хэнтий	68.0	69.2	69.9	70.4	70.9
Улаанбаатар					
Улаанбаатар	68.3	69.5	70.2	70.7	71.2

Аймгуудын хувьд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг үзэхэд Баян-Өлгий, Дундговь, Төв, Булган, Говьсүмбэр аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 2.5-3.3 жилээр их, Дорнод, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 1.2-3.8 жилээр бага байна. Дундаж наслалтын ялгаатай байдал нь тухайн аймгийн нас баралтын түвшин, ялангуяа нялхсын нас баралттай холбон тайлбарлаж болно.

Дундаж наслалтыг бүс нутгаар нь авч үзвэл манай аймгийн дундаж наслалт баруун бүс нутгийн дундаж наслалтаас 2010 онд 1.8 жилээр, 2012 онд 1.9 жилээр, 2014 онд 1.8 насаар тус тус доогуур байна.

Зураг 8. Хүн амын дундаж наслалт, баруун бүс




2015 онд 2118 хүүхэд иргэний бүртгэлийн мэдээгээр бүртгэгдсэн байна. 2010 оноос 189 хүүхдээр буюу 9.8 хувиар, 2013 оноос 50 хүүхдээр буюу 2.4 хувиар тус тус өссөн боловч 2014 оноос 53 хүнээр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Төрөлт, нас баралт, сумаар

Сум	Төрсөн хүүхэд						Нас барсан хүний тоо					
	2010	2011	2012	2013	2014	2015	2010	2011	2012	2013	2014	2015
Баруунтуруун	51	54	67	67	57	64	23	14	10	16	16	16
Бөхмөрөн	58	49	61	66	46	58	18	10	17	17	11	10
Давст	53	50	46	46	46	36	10	11	12	8	6	13
Завхан	37	51	56	45	54	40	11	13	9	13	9	14
Зүүнговь	73	79	63	68	76	75	12	16	15	14	10	16
Зүүнхангай	53	54	58	56	50	40	20	19	24	11	19	15
Малчин	70	72	59	61	68	59	24	15	14	15	16	13
Наранбулаг	129	122	119	112	118	113	24	19	25	23	24	25
Өлгий	58	64	70	63	60	54	20	17	13	14	20	17
Өмнөговь	117	120	116	117	133	134	19	40	26	22	23	27
Өндөрхангай	63	63	77	77	83	86	32	25	30	21	17	21
Сагил	68	65	72	71	59	62	15	14	11	14	14	7
Тариалан	124	115	117	109	131	124	31	21	24	22	24	25
Түргэн	35	56	45	56	59	51	19	14	19	13	10	7
Тэс	148	156	139	133	133	138	26	29	30	24	23	20
Ховд	61	70	52	63	59	63	16	17	18	17	18	15
Хяргас	65	64	60	57	52	58	20	18	10	19	11	10
Цагаанхайрхан	56	51	46	50	43	47	11	21	17	22	16	16
Улаангом	610	673	730	751	844	816	161	171	126	129	174	181
Дүн	1929	2028	2053	2068	2171	2118	512	504	450	434	461	468


2015 онд манай аймагт иргэний бүртгэлээр 468 нас баралт бүртгэгдсэн байна. Нас барсан хүн 2010 оноос 44 хүнээр буюу 8.6 хувиар буурч, 2012 оноос 18 хүнээр буюу 4.0 хувиар, 2014 оноор 7 хүнээр буюу 1.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Нас баралт, 2015 оноор



Манай аймгийн нас баралтыг насаар, хүйсээр харуулахад 37 наснаас хойш ерөнхийдөө эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь эрэгтэйчүүдийн ихэнх хувь нь хүнд хүчир ажил эрхлэдэг, ямар нэгэн зодоон зохион гадны халдлагад маш их өртдөг, мөн хорт зуршил болох архи, тамхи их хэмжээгээр хэрэглэж, түүнээс үүдэх өвчин эмгэг тусч байгаа нь эрэгтэйчүүдийн нас барах гол шалтгаан болж байна.

Зураг 10.Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, онуудаар



2015 оны цэвэр өсөлт 1650 байгаа нь 2010 оноос 16.4 хувиар, 2012 оноос 2.9 хувиар тус тус өсч 2014 оноос 3.5 хувиар буурсан байна.

## Хүснэгт 10 . Мянган хүнд ногдох төрөлт, нас баралт

Он	Улсын дундаж			Аймгийн дундаж		
	Төрөлт	Нас баралт		Төрөлт	Нас баралт	
		Бүгд	Амьд төрсөн 1000		Бүгд	Амьд төрсөн 1000
2010	23.1	6.7	20.2	26.2	7.7	4.7
2011	25.1	6.9	16.5	27.7	7.1	4.4
2012	26.0	6.3	15.5	28.0	4.5	4.3
2013	27.5	5.9	14.6	27.7	5.8	5.8
2014	28.3	5.7	15.1	28.7	6.1	2.8
2015	27.3	5.5	15.0	27.1	5.9	6.6

Хүн амын төрөлтийн ерөнхий коэффициент нь тухайн жилд мянган хүн ам тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоогоор илэрхийлэгдэнэ.

$$TEK_{2015} = \frac{\text{Тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000 = \frac{2118}{78067} * 1000 = 27.1$$

Төрөлтийг иргэний бүртгэлийн эх сурвалжийг үндэслэн тооцвол мянган хүний 27 хүн нь төрсөн байна. Манай аймгийн хүн амын төрөлтийн ерөнхий коэффициент сүүлийн жилүүдэд харьцангуй тогтворгүй байсан бөгөөд 2010 оноос 0.9 пунктээр өсч, 2012 оноос 0.9 пунктээр, 2014 оноос 1.6 пунктээр тус тус доогуур байна.

Улсын хэмжээнд 1990 оноос хойш хүн амын жилийн цэвэр өсөлт буурч байсан ч сүүлийн 5 жилд төрөлт нэмэгдэж 1000 хүн амд ногдох төрөлт 2010 онд дахин буурч 23.1 болж буурсан бол 2014 он хүртэл тасралтгүй нэмэгдэж, харин энэ онд 2014 оноос 1.0 пунктээр буурсан байна. Аймгийн 1000 хүн амд ногдох төрөлт улсын дунджаас 2010 онд 3.1 пунктээр, 2012 онд 2.0 пунктээр, 2014 онд 0.4 пунктээр тус тус доогуур, 2015 онд 0.2 пунктээр дээгүүр байна.

Зураг 11. 1000 хүн амд ногдох төрөлт



Төрөлтийн ерөнхий коэффициентийг эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, хөгшид бүгдийг хамарсан хүн амын дундаж тоогоор тооцдог учраас төрөлтийн түвшинг ойролцоогоор

илэрхийлж, судалгааны шаардлагыг тэр бүр хангаж чаддаггүй. Иймээс төрөлтийн тусгай коэффициентийг тооцож төрөлтийн түвшинг илүү нарийвчлан харуулдаг. Төрөлтийн тусгай коэффициент нь тухайн жилд 15-49 насны мянган эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоогоор илэрхийлэгдэнэ.

$$ТТК_{2015} = \frac{\text{Тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоо}}{\text{15 – 49 насны эмэгтэйчүүдийн тоо}} * 1000 = \frac{2118}{21150} * 1000 = 100.1$$

2015 онд төрөх насны мянган эмэгтэйчүүдэд 100 амьд төрсөн хүүхэд ногдож байна.

Нас баралтын ерөнхий коэффициент нь тухайн жилд мянган хүн ам тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

$$НБЕК_{2015} = \frac{\text{Нийт нас барсан хүний тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 1000 = \frac{468}{78067} * 1000 = 5.99$$

2015 онд мянган хүн тутмын 6 хүн нь нас барсан байна. Мөн хүн амын нас баралтын ерөнхий коэффициент сүүлийн жилүүдэд харьцангуй тогтворгүй байсан бөгөөд энэ онд 2010 оноос 1.8 пунктээр, 2014 оноос 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 12. 1000 хүн амд ногдох нас баралт



Манай улсын хүн амын нас баралтын ерөнхий коэффициент сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байсан бол 2011 онд 6.9 болж 2010 оныхоос 0.2 пунктээр өсч, 2015 он хүртэл тасралтгүй буурсаар 5.5 болж 2011 оныхоос 1.4 пунктээр, 2014 оныхоос 0.2 пунктээр тус тус буурчээ. Аймгийн 1000 хүн амд ногдох нас баралт улсын дунджаас 2010 онд 1.0 пунктээр дээгүүр, 2012 онд 1.8 пунктээр доогуур, 2015 онд 0.4 пунктээр дээгүүр байна.

Нялхсын нас баралтын коэффициент нь тухайн жилийн 1000 амьд төрөлтөнд ногдох 1 хүртлэх насандаа нас барсан нийт хүүхдийн тоогоор илэрхийлэгдэнэ.

$$ННБК_{2015} = \frac{\text{Нэг насандаа нас барсан хүүхдийн тоо}}{\text{Амьд төрсөн хүүхдийн тоо}} * 1000 = \frac{14}{2118} * 1000 = 6.6$$

Мянган амьд төрсөн хүүхэд дутмын 7 хүүхэд нь нэг хүртэл насандаа эндсэн байна. Нялхсын нас баралтын коэффициент нь сүүлийн жилүүдэд харьцангуй тогтворгүй байсан бөгөөд 2010 оноос 1.9 пунктээр, 2014 оноос 3.8 пунктээр тус тус өссөн байна.


#### 4. ӨРХ, АМ БҮЛИЙН БАЙДАЛ

Нийт 636 хос 2015 онд гэрлэлтээ бүртгүүлж, 26 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт 2010 оноос 2.9 дахин, өнгөрсөн оноос 0.2 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд 2013 онд маш өндөр 691 байсан байна. Гэр бүл цуцлалт 2010 оноос 3.7 хувиар, 2014 оноос 10.3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 11 . Гэрлэлт, цуцлалт, мянган хүнд ногдох гэрлэлт, цуцлалт

Он	Гэрлэлт	Цуцлалт	18 ба түүнээс дээш насны 1000 хүнд ногдох	
			Гэрлэлт	Цуцлалт
2010	213	27	4.9	0.6
2011	440	35	10.1	0.8
2012	586	25	13.4	0.6
2013	691	33	15.5	0.7
2014	635	29	14.0	0.6
2015	636	26	13.5	0.5

Зураг13. Гэрлэлт, цуцлалт



Гэрлэлтийн ерөнхий коэффициент нь тухайн жилийн 1000 хүн амд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлдэг. 2015 онд манай аймгийн 1000 хүн тутамд 8 гэрлэлт ногдож байна.

$$\text{ГЕК}_{2015} = \frac{\text{Гэрлэлтийн тоо}}{\text{Нийт хүн амын тоо}} * 1000 = \frac{636}{80396} * 1000 = 7.9$$

Гэрлэлтийн ерөнхий коэффициент нь гэрлэх насны ба гэрлэх насны бус хүн амыг хамруулан тооцдог тул нэлээд ерөнхий үзүүлэлт юм. Иймд нийт гэрлэсэн хүн амын тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын тоонд харьцуулж гэрлэлтийн тусгай коэффициентийг тодорхойлдог.


$$\text{ГТК}_{2015} = \frac{\text{Гэрлэлтийн тоо}}{\text{18 ба түүнээс дээш хүн амын тоо}} * 1000 = \frac{636}{46962} * 1000 = 13.5$$

18-аас дээш насны 1000 хүнд ногдох гэрлэлт 2010 оноос 8.6 пунктээр, 2012 оноос 0.1 пунктээр өссөн, 2014 оноос 0.5 пунктээр буурсан байна.

$$\text{СТК}_{2015} = \frac{\text{Нийт салсан гэр бүлийн тоо}}{\text{18 ба түүнээс дээш хүн амын тоо}} * 1000 = \frac{26}{46962} * 1000 = 0.5$$

Харин 18-аас дээш насны 1000 хүнд ногдох гэр бүл цуцлалтын чиг хандлага 2010 оноос 2013 он хүртэл маш хэлбэлзэлтэйгээр өсч байсан бөгөөд 2015 он хүртэл буурсаар 0.5 болсон байна. Мянган хүнд ногдох гэр бүл цуцлалт 2010 он, 2014 оноос тус тус 0.1 пунктээр буурсан байна.

Зураг 14. 1000 хүнд ногдох гэрлэлт, цуцлалт



Өөрөөр хэлбэл 18 наснаас дээш 1000 хүний 13 хос гэр бүлээ бүртгүүлж, 10000 хүний 5 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна.

Манай аймагт нийт 2999 өрх толгойлсон гэр бүлгүй хүн байгаагийн 2291 өрх толгойлсон хүн буюу 76.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тооны өсөлтөнд 18 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн нас баралт голлон нөлөөлж байна.

#### Хүснэгт 12. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, эмэгтэй, сумаар

Сум	Өрх толгойлсон ганц бие хүний тоо						Өрх толгойлсон эмэгтэйчүүд					
	2010	2011	2012	2013	2014	2015	2010	2011	2012	2013	2014	2015
Баруунтуруун	149	148	155	150	112	114	100	96	87	111	95	88
Бөхмөрөн	46	70	98	110	83	67	37	46	75	86	74	52
Давст	76	75	86	88	80	63	47	52	62	68	58	39
Завхан	95	130	130	127	87	62	67	93	93	91	71	42
Зүүнговь	118	127	135	143	129	98	89	86	103	112	99	81
Зүүнхангай	139	141	127	131	121	72	87	88	88	86	62	50
Малчин	120	122	122	76	79	55	82	76	85	52	72	44
Наранбулаг	209	157	225	180	153	138	146	117	160	170	143	92
Өлгий	102	106	108	118	108	126	74	77	78	92	91	95
Өмнөговь	190	142	169	145	159	160	148	106	79	99	113	113
Өндөрхангай	198	60	84	202	114	150	135	50	70	166	90	109
Сагил	126	126	142	145	142	137	88	88	81	83	81	88
Тариалан	174	146	168	195	132	117	122	101	109	127	107	76
Түргэн	112	139	133	112	98	93	89	98	94	106	92	74
Тэс	173	194	202	89	137	116	131	129	122	57	121	91
Ховд	133	133	133	114	96	38	91	103	103	97	79	27
Хяргас	115	86	101	130	90	116	71	58	75	82	68	65
Цагаанхайрхан	131	110	126	145	110	93	90	96	97	114	89	70
Улаангом	1,298	1,088	1,397	1,772	1,150	1,184	976	855	1,051	1,358	996	995
Дүн	3,704	3,300	3,841	4,172	3,180	2,999	2,670	2,415	2,712	3,157	2,601	2,291

Өрх толгойлсон, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 2010 оноос 14.2 хувиар, 2013 оноос 27.4 хувиар, 2014 оноос 11.9 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2015 онд 1481 болж 2010 оноос 33.5 хувиар, 2012 оноос 16.5 хувиар, 2014 оноос 11.9 хувиар тус тус буурч жил дараалан буурах хандлагатай байна.

Нийт өнчин хүүхдийн 1382 буюу 93.3 хувь нь хагас өнчин, 99 буюу 6.7 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо 2010 оноос 10.0 хувиар, 2012 оноос 13.9 хувиар, 2014 оноос 13.2 хувиар тус тус буурсан байна.

#### Хүснэгт 13. Өнчин хүүхдийн тоо, сумаар

Сум	Бүтэн өнчин хүүхдийн тоо						Хагас өнчин хүүхдийн тоо					
	2010	2011	2012	2013	2014	2015	2010	2011	2012	2013	2014	2015
Баруунтуруун	3	2	2	3	3	3	67	76	72	47	31	34
Бөхмөрөн	2	5	3	5	2	3	56	55	39	57	57	40
Давст	2	1	1	2	2	2	39	39	31	31	30	27
Завхан	2	2	0	3	3	3	46	38	30	23	17	18
Зүүнговь	4	4	4	3	3	3	83	59	45	34	26	31
Зүүнхангай	9	8	5	2	3	3	67	72	52	84	53	39
Малчин	2	1	3	2	2	2	84	72	75	45	53	48
Наранбулаг	7	5	5	5	12	7	106	113	121	121	112	93
Өлгий	1	0	0	0	0	0	52	63	69	51	43	57
Өмнөговь	10	7	10	8	13	12	129	118	117	125	124	108
Өндөрхангай	4	4	6	3	3	2	96	88	81	70	74	62
Сагил	4	5	6	6	6	8	67	64	53	53	56	45
Тариалан	7	9	6	6	6	6	92	87	98	80	78	24
Түргэн	2	3	4	4	3	2	78	48	38	41	43	26
Тэс	2	2	2	2	1	1	74	59	69	65	61	70
Ховд	5	7	7	5	5	1	40	33	33	38	38	39
Хяргас	2	4	7	5	0	0	53	43	31	55	34	44
Цагаанхайрхан	3	3	4	8	5	7	141	124	63	70	76	78
Улаангом	39	41	40	44	42	34	748	708	542	497	532	499
Дүн	110	113	115	116	114	99	2118	1959	1659	1587	1538	1382

Хагас өнчин хүүхдийн тоо 2010 оноос 34.7 хувиар, 2012 оноос 16.7 хувиар, 2014 оноос 10.1 хувиар тус тус буурсан байна

Зураг 15. Бүтэн болон хагас өнчин хүүхэд



Нийт хөгжлийн бэрхшээлтэй 4127 хүн 2015 онд бүртгэгдсэн нь 2010 оноос 1372 хүнээр буюу 49.8 хувиар, 2012 оноос 1273 хүнээр буюу 44.6 хувиар, 2014 оноос 706 хүнээр буюу 20.6 хувиар тус тус өссөн байна. Нийт хүн амын 5.1 хувийг хөгжлийн

бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 1823 буюу 44.2 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 14. Тахир дутуу хүний тоо, сумаар

Сум	2010	2011	2012	2013	2014	2015
Баруунтуруун	184	169	102	96	148	126
Бөхмөрөн	74	77	94	100	111	112
Давст	68	60	71	87	79	106
Завхан	117	86	105	107	100	102
Зүүнговь	114	119	96	88	102	144
Зүүнхангай	109	109	62	55	54	78
Малчин	67	84	87	112	119	139
Наранбулаг	151	169	193	184	197	284
Өлгий	87	115	101	115	140	161
Өмнөговь	111	118	145	178	205	196
Өндөрхангай	133	138	129	153	148	176
Сагил	73	73	73	75	88	106
Тариалан	177	171	125	227	224	257
Түргэн	73	74	95	89	86	107
Тэс	138	147	122	198	139	146
Ховд	88	104	100	101	124	134
Хяргас	56	55	72	76	88	106
Цагаанхайрхан	168	170	136	144	162	148
Улаангом	767	739	946	1043	1107	1499
Дүн	2755	2777	2854	3228	3421	4127

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 7.9 хувийг 0-14 насны, 3.1 хувийг 15-17 насны тахир дутуу хүүхдүүд, 89.0 хувийг хөдөлмөрийн насны тахир дутуу хүмүүс болон хөдөлмөрийн нас хэтэрсэн тахир дутуу хүмүүс эзэлж байна.

Зураг 16. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо



## 5. ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛ

Хүн амын мэдээллийн сан 2015 оны байдлаар 21212 өрх 100.0, 80.4 мянган хүн ам нь 100.0 хувьтайгаар байгуулагдсан байна. Уг мэдээллийн санг байгуулснаар 40 төрлийн хүснэгтийг баг, сум, аймгаар нь гаргаж авах боломжтойгоос гадна өрхийг өрхийн тэргүүлэгчдийн нэрсээр, сонгуулийн насны хүн амыг нэрсээр, цэргийн насны хүн амыг нэрсээр, хүн амыг насаар мөн бусад динамик хүснэгтүүдийг гаргаж авах боломжтой болсон.

Энэ нь багийн дарга нарын ажлыг маш их хөнгөвчилж богино хугацаанд олон төрлийн мэдээллийг боловсруулж гаргах чухал ач холбогдолтой үндэсний цахим сан болж чадсан байна.

Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг нэгдсэн журмаар бүрдүүлж, ҮСХ-нд байрлуулж байгаа нь мэдээллийн хурдтай байдал, үнэн зөв, бүрэн бүтэн, давхардалгүй, аюулгүй гэх мэт олон нөхцлүүдийг зэрэг бүрдүүлж байгаа юм.

Хүн ам, өрхийн бүртгэлийг онлайн системд оруулснаар хэрэглэгчдэд орон зай, цаг хугацаанаас үл хамааран ашиглах боломж олгож байгаа юм.

Цаашид аймгийн статистикийн мэргэжилтнүүдээс эхлэн баг, хорооны зохион байгуулагч хүртлэх хүн амын мэдээний бүх мэргэжилтнүүд энэ онлайн системийг өдөр тутмын ажилдаа ашиглаж, шинэчилж, системийн мэдээллийн санг баяжуулж, хяналт хийж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллахад ихээхэн анхаарч ажиллах шаардлагатай байна.

## 6. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

1980 - 2015 оны хоорондох нийт хүн амын динамик эгнээний үндсэн үзүүлэлтүүдийг хугацаанаас хамаарсан прогнозыг Фурьегийн цуваагаар тэгшрүүлэн 2020 хүртэлх хандлагыг тодорхойлоё:

Хугацааны цувааны аливаа элементийн хүрсэн түвшин нь хөгжлийн өнгөрсөн үеийн үр дүн ба эдийн засгийн ирээдүйн өсөлтийн урьдчилсан нөхцөлийг нэгэн зэрэг тодорхойлж байдаг түүний онцлог оршино. Хугацааны цувааны шинжилгээ нь объектын өөрчлөлтийн зүй тогтлыг илэрхийлэх, өнгөрсөн ба одоо үеийн холбоог тогтоох, ирээдүйн элементүүдийг урьдчилан харах бололцоо олгодог.

Хугацааны цувааг тэгшитгэн шинжлэхэд Фурьегийн цувааны тэгшитгэл онцгой байр эзэлдэг. Хугацааны цуваа, хугацааны давталтаас хэрхэн хамаарч өөрчлөгдсөнийг Фурьегийн тэгшитгэл маш сайн тусган харуулдаг. Энэ нь гармоник дээр түшиглэнэ. Тригонометрийн функцийг тусламжтайгаар тэгшитгэсэн санамсаргүй нэмэгдэхүүнийг гармоник гэнэ. Өнцгийн хэмжигдэхүүн нь судалгаа явуулж байгаа нийт үе хугацааны тоонд түүний дугаар тус бүрийн хувийн жинг  $2\pi$  - ээр үржүүлсэнтэй тэнцүү. Улирлаар болон жилээр дахин давтан хэлбэлздэг үзүүлэлтүүдийг Фурьегийн тэгшитгэлээр илэрхийлнэ.

Фурьегийн тэгшитгэлийн томъёо

$$Y_t = a_0 + a_1 t + b_0 \sin \frac{2\pi t}{T} + b_1 \cos \frac{2\pi t}{T} + \varepsilon_t$$

$$\left\{ \begin{array}{l} na_0 + a_1 \sum t + b_0 \sum \sin\left(\frac{2\pi t}{T}\right) + b_1 \sum \cos\left(\frac{2\pi t}{T}\right) = \sum Y \\ a_0 \sum t + a_1 \sum t^2 + b_0 \sum t \sin\left(\frac{2\pi t}{T}\right) + b_1 \sum t \cos\left(\frac{2\pi t}{T}\right) = \sum Yt \\ a_0 \sum \sin\left(\frac{2\pi t}{T}\right) + a_1 \sum t \sin\left(\frac{2\pi t}{T}\right) + b_0 \sum \sin\left(\frac{2\pi t}{T}\right)^2 + b_1 \sum \sin\left(\frac{2\pi t}{T}\right) \cos\left(\frac{2\pi t}{T}\right) = \sum Y \sin\left(\frac{2\pi t}{T}\right) \\ a_0 \sum \cos\left(\frac{2\pi t}{T}\right) + a_1 \sum t \cos\left(\frac{2\pi t}{T}\right) + b_0 \sum \sin\left(\frac{2\pi t}{T}\right) \cos\left(\frac{2\pi t}{T}\right) + b_1 \sum \cos\left(\frac{2\pi t}{T}\right)^2 = \sum Y \cos\left(\frac{2\pi t}{T}\right) \end{array} \right.$$

Дээрх задаргаагаар бодно. Үүнийг нарийвчлал сайтай, статистик ач холбогдолтой болгох үүднээс судалгааны EViews.7 программыг ашиглан боловсруулалт хийсэн.

Дараах үр дүн гарсан:

Хүснэгт 25. Нийт хүн ам, оноор

Он	Хүн амын тоо	Он	Хүн амын тоо
1980	72161	1998	94069
1981	73533	1999	91696
1982	75040	2000	87592
1983	74392	2001	85554
1984	76284	2002	83301
1985	77848	2003	83112
1986	77702	2004	81609
1987	80138	2005	80924
1988	79117	2006	81212
1989	81479	2007	79473
1990	88278	2008	77184
1991	96804	2009	77408
1992	98281	2010	74784
1993	96490	2011	74448
1994	97152	2012	74026
1995	98139	2013	75518
1996	97543	2014	75737
1997	93696	2015	80396

### Регрессийн шинжилгээний үр дүн:

Dependent Variable: Y  
Method: Least Squares  
Date: 05/13/16 Time: 16:45  
Sample: 1980 2015  
Included observations: 36

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	78348.30	1497.101	52.33333	0.0000
@TREND	272.0546	80.22492	3.391149	0.0019
SIN((2*3.14*@TREND)/36)	7377.189	1175.472	6.275936	0.0000
COS((2*3.14*@TREND)/36)	-9606.024	739.9292	-12.98236	0.0000
R-squared	0.875863	Mean dependent var		83114.44
Adjusted R-squared	0.864225	S.D. dependent var		8465.359
S.E. of regression	3119.282	Akaike info criterion		19.03303
Sum squared resid	3.11E+08	Schwarz criterion		19.20898
Log likelihood	-338.5946	Hannan-Quinn criter.		19.09444
F-statistic	75.26008	Durbin-Watson stat		0.506736
Prob(F-statistic)	0.000000			

### R-squared Детерминацийн коэффициент

Энэ коэффициент нь тооцоолсон регрессийн тэгшитгэл нь хамааралтай хэмжигдэхүүнийг хэдэн хувь тайлбарлаж чадахыг харуулна. Өөрөөр хэлбэл тооцоолж буй загварын хамааралтай хэмжигдэхүүн бидний сонгосон бусад хамааралгүй хэмжигдэхүүнээс хэдэн хувь хамаарч байгааг харуулна.

**Durbin-Watson stat=DW:** Шалгуур нь  $0 \leq DW \leq 4$  хооронд орших бөгөөд 0 рүү тэмүүлбэл сөрөг автокорреляцитай 4 лүү тэмүүлбэл эерэг автокорреляцитай гэж үздэг.  $DW \approx 2$  ойролцоо байвал судалгааг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Энэхүү тооцооны утгыг Дарбин-Уотсоны шинжүүрийн онолын утгатай жиших бөгөөд онолын утга нь дээд доод гэсэн хязгаартай байна. Хэрэв тооцооны утга онолын доод хязгаараас бага байвал автокорреляци байна, дээд хязгаараас их байвал автокорреляци байхгүй, эдгээр хязгаарт агуулагдаж байвал автокорреляци байгаа эсэхийг шалгах шаардлагатай гэж үздэг.

**t-Statistic** нь хувьсагчуудын ач холбогдолыг харуулдаг.  $F_{\text{бод}} > F_{\text{хүснэгт}}$  ач холбогдолтой.

**F-statistic:** Бодож гаргасан тэгшитгэлийг судалгаанд ашиглах эсэхийг шийддэг

$F_{\text{бод}} > F_{\text{хүснэгт}}$  ашиглана

$$F = \frac{R^2 / (k - 1)}{(1 - R^2) / (n - k)}$$

**Prob<0.1:** Статистик ач холбогдолтой гэж үздэг.

**Регрессийн шинжилгээгээр бодсон загвар:**

Estimation Command:

```
LS Y C @TREND SIN((2*3.14*@TREND)/36) COS((2*3.14*@TREND)/36)
```

Estimation Equation:


```
Y = C(1) + C(2)*@TREND + C(3)*SIN((2*3.14*@TREND)/36) + C(4)*COS((2*3.14*@TREND)/36)
```

Substituted Coefficients:

```
Y = 78348.2972518 + 272.05460637*@TREND + 7377.18920819*SIN((2*3.14*@TREND)/36) - 9606.02398614*COS((2*3.14*@TREND)/36)
```

Энэхүү загварыг ашиглан хугацаанаас хамаарсан 2020 он хүртлэх прогнозыг хийхэд дараах үр дүн гарлаа.

**График 6.1**



Он	Хүн амын тоо	Хугацаа	Хүн амын тоо прогнозын утга
	Ү	Trend	Үpred
1980	72161	0	68742
1981	73533	1	70441
1982	75040	2	72387
1983	74392	3	74531
1984	76284	4	76816
1985	77848	5	79180
1986	77702	6	81560
1987	80138	7	83892
1988	79117	8	86114
1989	81479	9	88166
1990	88278	10	89995
1991	96804	11	91552
1992	98281	12	92800
1993	96490	13	93708
1994	97152	14	94257
1995	98139	15	94439
1996	97543	16	94256
1997	93696	17	93723
1998	94069	18	92863
1999	91696	19	91711
2000	87592	20	90311
2001	85554	21	88713
2002	83301	22	86973
2003	83112	23	85154
2004	81609	24	83317
2005	80924	25	81528
2006	81212	26	79849
2007	79473	27	78340
2008	77184	28	77053
2009	77408	29	76037
2010	74784	30	75330
2011	74448	31	74963
2012	74026	32	74955
2013	75518	33	75314
2014	75737	34	76037
2015	80396	35	77112
2016	Прогнозын утга	36	78513
2017		37	80206
2018		38	82148
2019		39	84289
2020		40	86572

Сүүлийн 2 жилийн хувьд 2015 онд өмнөх оноосоо 4659 хүнээр, 2014 онд өмнөх оноосоо 219 хүнээр буюу 2012 оноос 8.6 хувиар өссөн байна. Прогнозоос харахад 2019 он гэхэд Увс аймгийн хүн амын тоо 84.3 мян.хүн буюу 2015 оныхоос 4.8 хувиар өсөхөөр, 2020 он гэхэд 86.6 мян.хүн буюу 7.8 хувиар өсөх хандлагатай байна.

Энэ зөвхөн хугацаанаас хамаарсан прогноз учраас хандлагын үр дүнг бүрэн гүйцэт тодорхойлж чадахгүй байх талтай ч боловч Увс аймгийн хувьд 2000 оноос хойш хүн амын тоо жил ирэх тусам буурч ирсэн нь хүн амын шилжих хөдөлгөөн, ажлын байрны хомсдол, дэд бүтцийн асуудал, бэлчээрийн хомсдол, салбарын өсөлт гэх мэт эдийн засгийн томоохон хүчин зүйлүүдээс шалтгаалж хүмүүс шилжин явах тэр хэмжээгээрээ хүн амын тоо буурах хандлагатай байх дүр төрх сүүлийн жилүүдэд ажиглагдаж байсан ч 2012 оноос хойш сүүлийн 4 жилийн хугацаанд хүн амын тоо тогтмол өссөн нь, мөн төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын үр дүн, түүний хэрэгжилт хүмүүст хүрч шилжих хөдөлгөөн багасах, хүний амын төрөлт нэмэгдэх, нас баралт буурах, ажлын байрууд нэмэгдэх гэх мэт ард иргэдийг тухайн орон нутагтаа ая тухтай ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай амьдрах боломж бий болгосонтой холбон тайлбарлаж болох юм.

## ДҮГНЭЛТ

Манай аймаг өнөөгийн байдлаар Монгол улсын хэмжээнд хүн амын тоогоороо бусад аймгуудтай харьцуулахад 2000 онд 8 дугаарт жагсаж байсан бол 2015 онд 12 дугаарт жагсаж хүн амын тоо ухарсан боловч, баруун бүсийн аймгуудаас 2000 онд ганцхан Говь-Алтай аймгийн өмнө орж байсан бол 2015 онд Говь-Алтай, Завхан аймгуудын өмнө хүн амын тоогоороо жагсаж байна.

Хүн ам, орон сууцны завсрын тооллогын бүртгэлд суурилсан хүн ам, өрхийн мэдээллийн сангаас үндэслэн гаргасан хүн амын тоогоор 2015 оны жилийн эцэст 40.4 мянган эрэгтэй, 39.9 мянган эмэгтэй нийт 80.4 мянган хүн тоологдсон байна. Хүн ам 2010 оноос 5.6 мянган хүнээр буюу 7.5 хувиар, 2014 оноос 4.6 мянган хүнээр буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

Манай аймгийн нэг өрхөд 3.8 хүн ногдож байна. Энэ үзүүлэлт нь 2012 оноос 0.08 пунктээр, 2013 оноос 0.07 пунктээр тус тус буурч, харин 2014 оноос 0.14 пунктээр нэмэгдсэн байна.

Хүйсийн харьцаа 2010 онд 100.5, 2015 онд 101.1 байгаа нь манай аймгийн хүн амд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа бөгөөд хүйсийн тэнцвэртэй байдлыг харуулж байна. Энэ онд хүйсийн харьцаа 101.1 байгаа нь 100 эмэгтэйд 101 эрэгтэй ногдож байна.

Улсын хэмжээнд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2014 оны байдлаар 69.6, эрэгтэйчүүдийнх 65.9, эмэгтэйчүүдийнх 75.5 байна. Монгол улсын хэмжээнд манай аймгийн хүн амын дундаж наслалт 68.3 байгаа нь 21 аймгийн сүүлээсээ хоёрдугаарт Хөвсгөл аймгийн өмнө орж байна.

Аймгуудын хувьд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг үзэхэд Баян-Өлгий, Дундговь, Төв, Булган, Говьсүмбэр аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 2.5-3.3 жилээр их, Дорнод, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 1.2-3.8 жилээр бага байна. Дундаж наслалтын ялгаатай байдал нь тухайн аймгийн нас баралтын түвшин, ялангуяа нялхсын нас баралттай холбон тайлбарлаж болно.

Улсын хэмжээнд 1990 оноос хойш хүн амын жилийн цэвэр өсөлт буурч байсан ч сүүлийн 5 жилд төрөлт нэмэгдэж 1000 хүн амд ногдох төрөлт 2010 онд 23.1 болж буурсан бол 2011-2014 он хүртэл тасралтгүй нэмэгдэж, харин энэ онд 2014 оноос 1.0 пунктээр буурсан байна. Аймгийн 1000 хүн амд ногдох төрөлт улсын дунджаас 2010 онд 3.1 пунктээр, 2012 онд 2.0 пунктээр, 2014 онд 0.4 пунктээр тус тус доогуур, 2015 онд 0.2 пунктээр дээгүүр байна.

Мянган амьд төрсөн хүүхэд дутмын 7 хүүхэд нь нэг хүртэл насандаа эндсэн байна. Нялхсын нас баралтын коэффициент нь сүүлийн жилүүдэд харьцангуй

тогтворгүй байсан бөгөөд 2010 оноос 1.9 пунктээр, 2014 оноос 3.8 пунктээр тус тус өссөн байна.

Манай аймагт нийт 2999 өрх толгойлсон гэр бүлгүй хүн байгаагийн 2291 өрх толгойлсон хүн буюу 76.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тооны өсөлтөнд 18 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн нас баралт голлон нөлөөлж байна.

Аймгийн хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2015 онд 1481 болж 2010 оноос 33.5 хувиар, 2012 оноос 16.5 хувиар, 2014 оноос 11.9 хувиар тус тус буурч жил дараалан буурах хандлагатай байна.

Нийт өнчин хүүхдийн 1382 буюу 93.3 хувь нь хагас өнчин, 99 буюу 6.7 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо 2010 оноос 10.0 хувиар, 2012 оноос 13.9 хувиар, 2014 оноос 13.2 хувиар тус тус буурсан байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй 4127 хүн 2015 онд бүртгэгдсэн нь 2010 оноос 1372 хүнээр буюу 49.8 хувиар, 2012 оноос 1273 хүнээр буюу 44.6 хувиар, 2014 оноос 706 хүнээр буюу 20.6 хувиар тус тус өссөн байна. Нийт хүн амын 5.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 1823 буюу 44.2 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 7.9 хувийг 0-14 насны, 3.1 хувийг 15-17 насны тахир дутуу хүүхдүүд, 89.0 хувийг хөдөлмөрийн насны тахир дутуу хүмүүс болон хөдөлмөрийн нас хэтэрсэн тахир дутуу хүмүүс эзэлж байна.

Хүн амын мэдээллийн сан 2015 оны байдлаар 21212 өрхийн 80.4 мянган хүн амтай 100.0 хувьтайгаар байгуулагдсан байна. Уг мэдээллийн санг байгуулснаар 40 төрлийн хүснэгтийг баг, сум, аймгаар нь гаргаж авах боломжтойгоос гадна өрхийг өрхийн тэргүүлэгчдийн нэрсээр, сонгуулийн насны хүн амыг нэрсээр, цэргийн насны хүн амыг нэрсээр, хүн амыг насаар мөн бусад динамик хүснэгтүүдийг гаргаж авах боломжтой болсон.

Сүүлийн 2 жилийн хувьд 2015 онд өмнөх оноосоо 4659 хүнээр, 2014 онд өмнөх оноосоо 219 хүнээр буюу 2012 оноос 8.6 хувиар өссөн байна. Прогнозоос харахад 2019 он гэхэд Увс аймгийн хүн амын тоо 84.3 мян.хүн буюу 2015 оныхоос 4.8 хувиар өсөхөөр, 2020 он гэхэд 86.6 мян.хүн буюу 7.8 хувиар өсөх хандлагатай байна.

Энэ зөвхөн хугацаанаас хамаарсан прогноз учраас хандлагын үр дүнг бүрэн гүйцэт тодорхойлж чадахгүй байх талтай ч боловч Увс аймгийн хувьд 2000 оноос хойш хүн амын тоо жил ирэх тусам буурч ирсэн нь хүн амын шилжих хөдөлгөөн, ажлын байрны хомсдол, дэд бүтцийн асуудал, бэлчээрийн хомсдол, салбарын өсөлт гэх мэт эдийн засгийн томоохон хүчин зүйлүүдээс шалтгаалж хүмүүс шилжин явах тэр

хэмжээгээрээ хүн амын тоо буурах хандлагатай байх дүр төрх сүүлийн жилүүдэд ажиглагдаж байсан ч 2012 оноос хойш сүүлийн 4 жилийн хугацаанд хүн амын тоо тогтмол өссөн нь монгол улсад анх удаа 2015 онд бүртгэлд суурилсан завсрын тооллого явагдсан, мөн төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын үр дүн, түүний хэрэгжилт хүмүүст хүрч шилжих хөдөлгөөн багасах, хүний амын төрөлт нэмэгдэх, нас баралт буурах, ажлын байрууд нэмэгдэх гэх мэт ард иргэдийг тухайн орон нутагтаа ая тухтай ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай амьдрах боломж бий болгосонтой холбон тайлбарлаж болох юм.

### Г. Судалгааны хамрах хүрээ

Үзүүлэлтүүдийг 2010-2015 оны гүйцэтгэлээр аймгийн дүнгээр тооцож, өсөлт, өөрчлөлтийг харуулахын тулд 2010 оныг суурь болгон, үзүүлэлт дээр зэрэгцүүлэн дүгнэлт хийлээ.

### Д. Мэдээллийн эх үүсвэр

- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2015 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2014 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2013 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2012 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2011 он
- Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар 2010 он
- 2010 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- 2011 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- 2012 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- 2013 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- 2014 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- 2015 оны аймгийн статистикийн эмхэтгэл
- Судалгааны EVIEWS 7.1 програм болон Microsoft компаний office 2010 орчны хэрэглээний програмуудыг ашигласан.

Судалгааг хийсэн: Мэргэжилтэн П. Тунгалаг